



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.05.12 № 521
танай _____-ы № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Д.ОТГОНБАЯР ТАНАА

Нэгдсэн удирдамжийн дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 3.7 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ж.БАНБААТАР

232530521



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ
ХАНГАЛТГҮЙ, ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ МУУ
БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ,
ҮР ДҮН
АУДИТЫН КОД: ХЭА-2025/21-22-ШТА-НА

Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор
Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Билэгсайхан
Утас: 88032817 Цахим хаяг: bilegsaikhants@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Оюундарь
Утас: 99565533 Цахим хаяг: oyundarib@audit.gov.mn

Чингис хот
2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

**Тайланг бэлтгэсэн:**

Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын
газар:

Ахлах аудитор

Ц.Билэгсайхан

Аудитор

Б.Оюундарь

2025 оны 5 дугаар
сар

Тайланг **ҮАГ-ын**
цахим сайтаас үзнэ
үү.

www.audit.mn

Хаяг:

Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын
газар,

Хэрлэн сум, 4-р баг,
аймгийн ЗДТГ-ын
байр,

Чингис хот

Хэнтий аймаг

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	2
Ерөнхий зүйл.....	3
Бүлэг 1. Хэмнэх шаардлагатай зардалтай холбоотой зөрчил буурсан хэдий ч хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллахгүй байна.....	5
1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллахгүй байна.....	5
1.2. Хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах шаардлагатай байна.....	6
Бүлэг 2. Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмын хэрэгжилт хангалтгүй байна.....	7
2.1. Барилгын ашиглалтын норм дууссан талаар эрх бүхий этгээдийн шийдвэр гараагүй, магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөвгүй барилгыг шинээр төлөвлөн хэрэгжүүлж байна.....	7
2.2. Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээний тоо, төрөл бага, сонголт муу байгаагаас худалдан авалт хангалтгүй байна.	8
Бүлэг 3. Төрийн байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллаагүй байна.....	9
3.1. Орон нутагт хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.....	9
3.2. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт хангалтгүй байна..	10
3.3. Шилэн дансны тухай хуулийг хангалттай хэрэгжүүлэн ажиллаж байна.....	12
Аудитын дүгнэлт	13
Зөвлөмж:	14
Тайланг баталгаажуулсан тушаал	15

Товчилсон үгийн жагсаалт

ТОВЧИЛСОН ҮГ	ТАЙЛБАР
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ХШҮХ	Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс

Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.10-т заасан бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэсэн. Үүнд:

- ❖ Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх;
- ❖ Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан эсэх;
- ❖ Засгийн газар болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг аймгийн 2022, 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай уялдуулан, Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд, зарим ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг түүвэрт хамруулж холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБООУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглана. Үүнд:

- ❖ Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль;
- ❖ Төсвийн тухай хууль;
- ❖ Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- ❖ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ❖ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ❖ Авто замын тухай хууль;
- ❖ Ашигт малтмалын тухай хууль;
- ❖ Барилгын тухай хууль;
- ❖ Боловсролын тухай хууль;
- ❖ Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
- ❖ Төрийн албаны тухай хууль;

- ❖ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- ❖ Статистикийн тухай хууль;
- ❖ Соёлын тухай хууль;
- ❖ Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль;
- ❖ Нийгмийн халамжийн тухай хууль;
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ❖ Харилцаа холбооны тухай хууль;
- ❖ Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль;
- ❖ Эрчим хүчний тухай хууль;
- ❖ Эрүүл мэндийн тухай хууль;
- ❖ Засгийн газрын 2024 оны 44 дүгээр тогтоолоор баталсан “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”;
- ❖ Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”;
- ❖ Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- ❖ Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”;
- ❖ Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- ❖ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- ❖ Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд;
- ❖ Аймгийн 2022, 2023, 2024 оны төсөв баталсан болон тодотгон баталсан аймгийн ИТХ-ын тогтоолууд.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар хянан удирдаж, аудитын менежер Д.Оюунтуяа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Билэгсайхан, аудитор Б.Оюундарь нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу төлөвлөлтийн үе шатны ажлыг хэрэгжүүлэн 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр төлөвлөгөөг батлуулсан.

Гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэл хугацаанд хийж дуусган, тайлан, судалгаа, дүгнэлтийг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл

Төрийн хэмнэлтийн тухай хууль нь 2022 онд 4 бүлэг 22 зүйл заалттай батлагдаж, Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2022 онд 1 удаа, 2023 онд 2 удаа, 2024 онд 3 удаа тус тус нэмэлт өөрчлөлт оруулж баталсан байна.

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтын хүрээнд МУЕА-ын 2022 оны А/59 дүгээр тушаалаар

баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын дагуу хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Төсвийн шууд болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022-2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитад 2022 онд 300 байгууллага, 2023 онд 286 байгууллага, 2024 онд 287 байгууллагыг тус тус хамруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар 2022 онд 1,305.6 сая төгрөгийн 102 зөрчил, 2023 онд 328.6 сая төгрөгийн 14 зөрчил, 2024 онд 470.7 сая төгрөгийн 13 зөрчлийг тус илрүүлсэн байна.

Бүлэг 1. Хэмнэх шаардлагатай зардалтай холбоотой зөрчил буурсан хэдий ч хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллахгүй байна.

1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн шууд болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилтэд МУЕА-ын 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын дагуу хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг зөрчсөн үндэслэлээр 5.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3 албан шаардлагыг өгч ажилласан байна.

Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг зөрчсөн үндэслэлээр 2.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь заалтыг зөрчсөн үндэслэлээр 12.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 1

сая.төгрөг

Зөрчсөн хуулийн заалт	Аудитын шийдвэрийн		
	Дүн	Тоо	Төрөл
ТХ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт /Тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглох/	1.6	1	Төлбөрийн акт
	4.1	3	Албан шаардлага
ТХ-ийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт /дүрэмт хувцас худалдан авах/	2.6	1	Төлбөрийн акт
ТХ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь заалт /гар утас, хэвлэл захиалга/	10.0	1	Төлбөрийн акт
	2.5	1	Зөвлөмж
НИЙТ	20.8	7	

Эх сурвалж: Төсвийн шууд болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн мэдээлэл

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтын дагуу аймгийн ЗДТГ-ын 2022, 2023 оны бүтэц орон тоо баталсан 2 шийдвэр, 18 сумын ЗДТГ, 4 тосгоны ЗАА-ны 2022-2024 оны бүтэц орон тоо баталсан 38 шийдвэрийг гаргуулан авч дүн шинжилгээ хийн ажилласан. Эдгээр бүтэц, орон тоо баталсан шийдвэрт нэгээс илүү орлогч даргыг батлаагүй байна.

Мөн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтын хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын 2024 оны бүтэц орон тоо баталсан 1 тогтоол, сумдын ИТХ-ын 2021-2024 оны бүтэц, орон тоо баталсан 19 тогтоол, "Харгуй" ТӨХК-ий төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 он, "Хэнтий-Ус" ХХК-ий төлөөлөн удирдах зөвлөлийн 2023, 2024 оны бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай тогтоолд зөвлөх чиг үүрэг бүхий орон тоо баталсан эсэхийг тулган шалгасан. Бүтэц, орон тоо баталсан эдгээр тогтоолд зөвлөхийн чиг үүрэг бүхий орон тоог батлаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын дагуу 2022-2024 онуудад Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу холбогдох байгууллагын зайлшгүй шаардлага, хэрэгцээг үндэслэн 36 автомашиныг зөвшөөрсөн байгууллагад шилжүүлж, 57 автомашиныг дуудлагын худалдаагаар худалдан борлуулж, ашиглалтын шаардлага хангахгүй 72 автомашиныг акталсан байна.

Авто тээврийн үндэсний төв болон аймгийн Авто тээврийн төвөөс ирүүлсэн мэдээллийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй 572 тээврийн хэрэгсэлд цэнхэр дугаарыг сольсон эсэх, ашиглалтын байдлыг шалган үзэхэд 4 байгууллага, 13 тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солиогүй байна. Үүнд:

- **Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 419-р нээлттэй хорих анги 2 автомашин;**
- **Хэнтий аймгийн Хэрлэн сумын ЗДТГазар 2 автомашин;**
- **Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ЗДТГазар 1 мотоцикль;**
- **Хэнтий аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар 8 мотоцикль тус тус байна.**

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 /Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ/ дэх заалтыг зөрчиж тухайн байгууллагын удирдлага хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй, дээд шатны байгууллага албан тушаалтан хяналт тавьж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

1.2. Хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах шаардлагатай байна.

Аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд холбогдох заалтын хүрээнд 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 565.6 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж 36 сая төгрөгийн 20 төлбөрийн акт тогтоож, 213.5 сая төгрөгийн 27 албан шаардлага, 316,1 сая төгрөгийн 37 зөвлөмжийг өгч байсан бол 2023 онд 3.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 2024 онд 1.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актыг тогтоож ажилласан байна.

Дээрх үзүүлэлтээс үзэхэд зөрчлийн тоо буурч байгаа хэдий ч Төрийн хэмнэлтийн тухай хууль бүрэн хэрэгжихгүй байна.

"Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл" МОН-1907-ийн хүрээнд Санхүү, эдийн засгийн яам, Хэнтий аймгийн ЗДТГ хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 1,975.2 сая төгрөг, "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт"

МОН-3713 төслийн хүрээнд Сангийн яам, Хэнтий аймгийн ЗДТГ хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 2,990.0 мянган ам долларын зээлийг авсан байна.

МОН-1907 зээлийн гэрээний хувьд 2010 оноос 11 сараас эхлэн зээлийг төлж эхлэх байсан боловч 2022 оныг хүртэл хугацаанд эргэн төлөлтийг хийгээгүй байна. 2022-2024 оны хугацаанд зээлийн үндсэн төлбөрт 1,281.0 сая төгрөгийг, хүүгийн төлбөрт 169.6 сая төгрөгийг төлж 2024 оны жилийн эцсийн байдлаар 759.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэхүү үлдэгдлийг хуваарийн дагуу 2024 оны жилийн эцсийн үлдэгдэлтэй харьцуулан үзэхэд 375.1 сая төгрөгийн дутуу төлсөн байна.

МОН-3713 төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний хувьд 2020 оноос 2024 оныг дуустал хугацаанд зээлийн хүүд нийт 367.7 мянган ам.долларыг төлөхөөр байсан бол 2022 онд 174.8 мянган ам.долларын хүүг төлж 192.9 мянган ам.доллар буюу Монгол банкны ханшаар тооцож үзвэл 689.1 сая төгрөгийг дутуу төлсөн байна. Энэхүү зээл нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 3,409.6 мянган ам доллар буюу төгрөгт шилжүүлснээр 11,661.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- **“Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл” МОН-1907- зээлийн үндсэн төлбөр 375.1 сая төгрөг /газар доорх шугам сүлжээ/;**
- **“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл” МОН-3713- зээлийн хүүгийн төлбөр 689.1 сая төгрөг /цэвэрлэх байгууламж/ байна.**

Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс төсвийн төслийг боловсруулах явцад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зардалд төсвийг илүү хуваарилдаг учир зээлийн эргэн төлөлтийг хийх, өр төлбөрийг барагдуулах зардалд гэрээнд заасан төлөлтийг төсөвт бүрэн тусгаж чаддаггүй байна.

"Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т заасны дагуу хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө, хуваарийг батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаагүй байна.

Бүлэг 2. Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмын хэрэгжилт хангалтгүй байна.

2.1. Барилгын ашиглалтын норм дууссан талаар эрх бүхий этгээдийн шийдвэр гараагүй, магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөвгүй барилгыг шинээр төлөвлөн хэрэгжүүлж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтын хүрээнд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлттэй холбоотой асуудлаар горим сорил хэрэгжүүлэн ажиллалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас 2023 онд аймгийн Засаг даргад хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн 32 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжих ажлууд байсан бол 2024 онд хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн 10 төсөл, арга хэмжээний 6 төсөл, арга хэмжээ нь шинээр хэрэгжүүлэх ажил байсан бөгөөд худалдан авах ажиллагааны үр дүнд 655.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

Энэхүү хэмнэлт нь Худалдан авах ажиллагааны үр дүнгээр гарсан төсөвт өртгийн дүнгээр гүйцэтгэгч болон захиалагч, зохиогчийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй

гэрээ байгуулж, тус гэрээний дагуу гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчаас шилжүүлдэг тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх үйл ажиллагаа хийгддэггүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хувьд 2022 онд 18 ажилд худалдан авах ажиллагааг зохион байгуулж 191.3 сая төгрөг, 2023 онд 35 ажилд худалдан авах ажиллагааг зохион байгуулж 465.3 сая төгрөг, 2024 онд 20 ажилд худалдан авах ажлыг зохион байгуулж 341.0 сая төгрөгийн хэмнэлтийг тус тус бий болгосон байна.

Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалтын хүрээнд барилга байгууламжийн ашиглалтын хугацааны норм дуусахаас өмнө ижил төрлийн барилга байгууламж дахин шинээр барих төслийн санал гаргахгүй байх тухай асуудлыг Монгол Улсын 2023, 2024 оны Төсвийн тухай хуульд тусгагдан 2020-2022 оноос эхлэн он дамжин хэрэгжиж байгаа 10 төсөл, арга хэмжээг хамруулж шалган үзлээ.

Хуучин ашиглаж байсан барилгад ашиглалтын хугацааны норм дууссан талаар барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан, зориулалт бус барилгад үйл ажиллагаа явуулж байсан гэсэн үндэслэлээр 3 төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалтад нийцэж байгаа бол 7 төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг нь энэхүү заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 02 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 36 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээ нь магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөвгүй байна. Үүнд:

- **Аймгийн Онцгой байдлын газрын сургалт, сурталчилгааны төвийн байр, тохижилт 300.0 сая төгрөг**
- **Багийн төвийн барилга /Биндэр сум, Баян-Өндөр баг, Галшар сум Оч баг/ 193.7 сая төгрөг**
- **Иргэдэд үйлчлэх нэгдсэн төвийн засвар /Хэрлэн сум/ 114.0 сая төгрөг**
- **1-р багийн төвийн засвар /Хэрлэн/ 89.5 сая төгрөг**

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, 13.3.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

2.2. Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээний тоо, төрөл бага, сонголт муу байгаагаас худалдан авалт хангалтгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд холбогдох заалтын хүрээнд 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 705.3 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага, 13.8 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг өгч хэрэгжилтийг хангуулан ажилласны дүнд 2023 оны аудитаар 108.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 20.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 2024 онд 169.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлагыг хүргүүлж алдаа зөрчлийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

Цахим худалдан авалттай холбоотой үйл ажиллагааны хэрэгжилт, тулгарч байгаа хүндрэлтэй асуудлын талаар төсвийн болон орон нутгийн өмчит 132 байгууллагыг хамруулсан судалгааг хийсэн.

Судалгаанаас үзэхэд хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь заалтын хүрээнд тухайн жилд худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлэх, бараа, үйлчилгээний төрөл нэмүүлэх хүсэлт хүргүүлэх ажлыг хэрэгжүүлэхгүй байна.

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтын хүрээнд 2023 онд 24 байгууллага 841.9 сая төгрөг, 2024 онд 21 байгууллага 687.9 сая төгрөгийн бараа, үйлчилгээг худалдан авч үйл ажиллагаандаа ашиглан ажилласан байна.

Мөн цахим дэлгүүрт байршуулсан бараа нь зах зээлийн үнээс өндөр, барааны нэр төрөл цөөн, эм эмнэлгийн хэрэгслийг цөөн тоогоор захиалахад хүргэлт удаашралтай хугацаа алддаг зэрэг хүндрэлтэй асуудлууд үүсдэг байна.

Бүлэг 3. Төрийн байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллаагүй байна.

3.1. Орон нутагт хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэгч АЗДТГ-ын СТСХэлтэс болон ХШҮХэлтэсээс ирүүлсэн мэдээлэл, нотлох баримтыг судалж үзэхэд тус хэлтэс нь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас төрийн цахим систем New.unelgee.gov.mn-ээр хууль тогтоомжийн биелэлтийг сар бүр гарган ажилладаг бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамааралтай 5 зүйлийн холбогдох заалтын биелэлтийг харьяа байгууллагаас гаргуулан авч тайлагнадаг байна.

Хүснэгт 2

д/д	Тайлагнасан он	Хуулийн заалт	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл
1	2022	20 дугаар зүйлийн 20.5	Засгийн газрын 204 дүгээр тогтоол	
2	2023	5 дугаар зүйлийн 5.2, 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1	Засгийн газрын 204 дүгээр тогтоол	ЗГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэл
3	2024	8 дугаар зүйлийн 8.1, 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйл 15 дугаар зүйл		ЗГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэл

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн хяналт хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтын дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллагын чиг үүргийг орон нутаг хэрэгжүүлэх үүрэг бүхий АЗДТГ-ын СТСХэлтэс, ХШҮХэлтэс нь тус хуулийн хэрэгжилтэд бүх байгууллагыг хамруулан бүхэлд нь хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллагаас тодорхой нарийвчилсан чиглэл ирдэггүй, аймгийн ЗДТГазар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтуудыг хяналтдаа аваагүй, хуулийн дагуу хяналт хэрэгжүүлж ажилладаггүйтэй холбоотой байна.

3.2. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших ТЕЗ-ийн эрхлэх асуудлын байгууллагуудын 2023-2024 оны төсвийн гүйцэтгэлээс үзэхэд 2023 онд 81,754.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 10,777.8 сая төгрөгийг дутуу зарцуулж, үүнээс 103.4 сая төгрөгийг хэмнэлт гарган ажилласан байна.

Хүснэгт 3

сая.төгрөг


д/д	Хуулийн холбогдох заалт	Утга	Хэмнэсэн мөнгөн дүн
1	Хуулийн 5 дугаар зүйлийн 5.2	Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно.	33.8
2	4 дүгээр зүйлийн 4.2.8	Цахимжуулалт болон инновацыг дэмжих замаар үрэлгэн байдлын эсрэг саад тотгорыг арилгах	20.6
3	8 дугаар зүйл	Дүрэмт хувцас	7.6
4	9 дүгээр зүйл	Албан томилолт	19.0
5	15 дугаар зүйлийн 15.2.7	сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх.	22.4
НИЙТ			103.4

Эх сурвалж: Төсвийн шууд болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн мэдээлэл

2024 онд 106,479.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 12,575.9 сая төгрөгийг дутуу зарцуулж, 165.6 сая төгрөгийг хэмнэлтийг гаргасан байна.

Дүрслэл 1

сая.төгрөг



Эх сурвалж: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын байгууллагуудын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол /үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах/-д заасан хувьтай харьцуулан үзэхэд 2023 онд 103.4 сая, 2024 онд 165.6 сая төгрөгийн хэмнэлт нь 0.00013 хувь буюу маш хангалтгүй хэмжээнд байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд 2022 оны батлагдсан төсвийг 2024 оны төсөвтэй харьцуулан үзэхэд 67 хувийн өсөлттэй байгаагаас урсгал зардал 87.2 хувь, хөрөнгийн зардал 45.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 4

сая.төгрөг

ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	2022 оны төсөв		2023 оны төсөв		2024 оны төсөв		2024 оныг 2022 оны төсөвтэй харьцуулсан хувь
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	
УРСГАЛ ЗАРДАЛ	38,122.90	34,236.12	48,225.02	44,094.69	71,352.10	65,801.20	87.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,620.69	18,952.74	27,217.42	24,649.40	31,443.37	27,029.68	45.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4,017.86	763.26	6,312.14	2,232.72	3,683.64	1,072.38	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,761.45	53,952.12	81,754.58	70,976.81	106,479.11	93,903.26	67.0

Эх сурвалж: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын байгууллагуудын 2022-2024 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл

Урсгал зардлаас цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн нэмэгдэл нь 100.9 хувь байгаа бөгөөд энэ нь Засгийн газраас төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн зардлыг 2024 оныг 2022 онтой харьцуулахад 9,822.7 сая төгрөг буюу 45.4 хувиар өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 10,712.9 сая төгрөг буюу 136.0 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 5

сая.төгрөг

Эдийн засгийн ангилал	2022 оны төсөв	2024 оны төсөв	Зөрүү	Нэмэгдсэн хувь
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,313.44	19,299.32	7,985.88	70.6
Хангамж, бараа материалын зардал	876.31	1,451.65	575.34	65.7
Эд хогшил, урсгал засварын зардал	1,471.44	2,912.58	1,441.13	97.9
Томилолт, зочны зардал	232.18	728.93	496.75	213.9

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,576.33	9,558.67	3,982.34	71.4
Бараа үйлчилгээний бусад зардал	4,003.08	7,535.62	3,532.55	88.2

Эх сурвалж: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын байгууллагуудын 2022-2024 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл

Эдийн засгийн ангиллаар дээрх зардлуудын хувьд хангамж, бараа материалын зардал 65.7 хувь, эд хогшил, урсгал засварын зардал 97.9 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 70.6 хувь, аймаг, сумын Засаг даргын нөөц сан болон эрсдэлийн сангийн хөрөнгийг 88.2 хувиар тус тус нэмэгдүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцэхгүй байна.


3.3. Шилэн дансны тухай хуулийг хангалттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн шууд болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалган холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийн тоо 2023 оны хувьд 2022 оноос 3.4 дахин, 2024 оны хувьд 2023 оноос 3 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл 2

сая.төгрөг



Эх сурвалж: Төсвийн шууд болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн мэдээлэл

Аудитын хүрээнд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалтын хэрэгжилтэд 20 байгууллагыг түүвэр байдлаар хамруулан шалгаж үзэхэд төсөв хэмнэсэн болон хэтэрсэн төсвийн гүйцэтгэлийг цахим системд мэдээлж байгаа боловч холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар мэдээллийг оруулж ажиллахгүй байна.

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй 4 байгууллага 13 тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солиогүй байна.
- Сангийн яам, аймгийн ЗДТГ-ын хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу эргэн төлөлтийг хугацаандаа хийхгүй, 1,064.2 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна.
- Барилга, байгууламжийн ашиглалтын хугацааны норм дууссан болон ашиглах боломжгүй болсон тухай барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг гараагүй 7 барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн байна.
- Орон нутагт Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий байгууллага нь хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.
- Аймгийн 2024 оны батлагдсан төсвийг 2022 оны төсөвтэй харьцуулан үзэхэд 422,717.7 сая төгрөг буюу 67 хувиар өссөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Зөвлөмж:

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

- ❖ Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр авсан зээлийг эргэн төлөх төлөвлөгөө, хуваарийг батлуулж, хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлтөд шаардагдах төсвийг төлөвлөн батлуулж ажиллах.
- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний саналыг гаргахдаа өмнө нь ашиглаж байсан ижил төрлийн барилга, байгууламжийн ашиглалтын хугацааны норм дууссан болон ашиглах боломжгүй болсон тухай барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг гаргуулж ажиллах
- ❖ Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь чиг үүргийнхээ хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, дүнг Засаг даргад танилцуулж ажиллах.
- ❖ Хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,

Чингис хот, Хэнтий аймаг, 23117

Утас/Факс: (976) 7056 2412

Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2025.05.12 № 9/1050

танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, түүний үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлантай холбоотой санал байхгүй болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮВ ОРДОН
ГҮЙЦЭТГЭГЧ

А.ЖАРГАЛСАЙХАН



*Ахлах аудитор
Н.Б.Билэгийн хатуу*

Ташин

*Хатуу
2/12*

231071-67

Тайланг баталгаажуулсан тушаал



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 05 дугаар сарын 12

Дугаар А/25

Чингис хот

Аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 10 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, МУЕА-ын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Эрсдэлийн удирдлагын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад хүргүүлэхийг ахлах аудитор /Ц.Билэгсайхан/-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, түүний биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлтийг Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Аюурбунь/-д зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг ахлах аудитор /Ц.Билэгсайхан/-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Д.Оюунтуяа/-г даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ТАНБААТАР

232501025

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхарт
Утас: +976 70562112
И-мэйл хаяг: khentii@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn

Аудитын нэр: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн

Аудитын асуулт, дүнгийн маягт

Аудитын асуулт	2 дахь түвшингийн асуулт	3 дахь түвшингийн асуулт	Аудитын нотлох зүйлийн дүн	Үр дагавар	Аудитын товч дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн	1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу?	1.1. Хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан уу?	Авто тээврийн үндэсний төв, аймгийн авто тээврийн төвөөс ирүүлсэн мэдээлэлд үндэслэн байгууллагуудын тээврийн хэрэгслийн цэнхэр дугаарын ашиглалтыг тулгасан тухай баримт	Дунд	Авто тээврийн үндэсний төв болон аймгийн Авто тээврийн төвөөс ирүүлсэн мэдээллийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй 572 тээврийн хэрэгсэлд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг хэрэгжилтийг шалган үзэхэд хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй 4 байгууллага, 13 тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солиогүй байна.
		1.2. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хэмнэлтийн бусад арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан уу?	Сангийн яам, аймгийн ЗДТГ-ын хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу эргэн төлөлт хийж тооцоо нийлсэн акт, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч Д.Цэцэгсүрэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл	Дунд	МОН-1907 зээлийн гэрээний хувьд 2010 оноос 11 сараас эхлэн зээлийг төлж эхлэх байсан боловч 2022 оныг хүртэл хугацаанд эргэн төлөлтийг хийгээгүй байна. 2022-2024 оны хугацаанд зээлийн үндсэн төлбөрт 1,281.0 сая төгрөгийг, хүүгийн төлбөрт 169.6 сая төгрөгийг төлж 2024 оны жилийн эцсийн байдлаар 759.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэхүү үлдэгдлийг хуваарийн дагуу 2024 оны жилийн эцсийн үлдэгдэлтэй харьцуулан үзэхэд 375.1 сая төгрөгийн дутуу төлсөн байна. МОН-3713 төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний хувьд 2020 оноос 2024 оныг дуусгал хугацаанд зээлийн хүүд нийт 367.7 мянган ам.долларыг төлөхөөр байсан бол 2022 онд 174.8 мянган ам.долларын хүүг төлж 192.9 мянган ам.доллар буюу Монгол банкны ханшаар тооцож үзвэл 689.1 сая төгрөгийг дутуу төлсөн байна. "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т заасны дагуу хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө, хуваарийг батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаагүй байна.
	2.1. Хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан уу?	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс ирүүлсэн барилга байгууламжийн ашиглалтын норм дууссан, ашиглах боломжгүй эсэхийг тогтоосон эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан талаар сумдаас ирүүлсэн баримт бичиг,	Дунд	Монгол Улсын 2023, 2024 оны Төсвийн тухай хуулинд тусгагдсан 2020-2022 оноос хэрэгжиж эхэлсэн, он дамжин хэрэгжиж байгаа 10 төсөл, арга хэмжээний өмнө ашиглаж байсан барилга байгууламжийн ашиглалтын норм дууссан, ашиглах боломжгүй эсэхийг тогтоосон эрх бүхий этгээдийн шийдвэр байгаа эсэхийг шалган үзлээ. Хуучин ашиглаж байсан барилгад ашиглалтын хугацааны норм дууссан талаар барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан, зориулалт бус барилгад үйл ажиллагаа явуулж байсан гэсэн үндэслэлээр 3 төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалтад нийцэж байгаа бол 7 төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг нь энэхүү заалттай нийцэхгүй байна. Мөн аймгийн ИТХ-ын 2024 ны 02 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 36 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээ нь магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөвгүй байна.	
	2. Хөрөнгө оруулалтай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу?				

	2.2. Цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулж ажилласан уу?	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Цахим худалдан авалттай холбоотой асуудлаар аймгийн СТСХ-тэй хамтран google.forms ашиглан авсан судалгаа	Дунд	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн хэрэгжилтэд төсвийн болон орон нутгийн өмчит 132 байгууллагыг хамруулсан судалгааг хийсэн. Судалгаанаас үзэхэд хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь заалтын хүрээнд тухайн жилд худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлэх, бараа, үйлчилгээний төрөл нэмүүлэх хүсэлт хүргүүлэх ажлыг хэрэгжүүлэхгүй байна. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтын хүрээнд 2023 онд 24 байгууллага 841.9 сая төгрөг, 2024 онд 21 байгууллага 687.9 сая төгрөгийн бараа, үйлчилгээг худалдан авч үйл ажиллагаандаа ашиглан ажилласан байна.
